

на. Гэвч далайн эргийн бусад бүс нутагтай харьцуулахад эдүгээ нэлээд хоцрогдонгуй байгаа эдийн засгийн бэрхшээлийг давж туулна гэдэг амаргүй билээ. Гагцхүү нээлттэй бодлогын уян хатан механизмыг мужийн давуу талтай зөв хослуулж чадсан цагт сая амжилт олж чадна.

¹ "Far eastern economic review" 1989 No 20

² Дэн Сяопин, «Основные вопросы современного Китая» М., 1988. с. 56-57

³ «Жэньминь жибао» 1988. IV.14

⁴ "Beijing review" 1988 No 18

⁵ «Новое время, 1989. No 20

⁶ «Жэньминь жибао» 1988. Ш. 6

⁷ «Жэньминь жибао» 1988. V.5

⁸ «Жэньминь жибао» 1988.V Ш.26

⁹ "China reconstructs" 1988 No 12 –

¹⁰ «Жэньминь жибао» 1989.1.1

¹¹ "China reconstructs" 1988 No 12

¹² «Жэньминь жибао» 1989 1.16

¹³ «Вэньхуй бао» 1989. 1.12

**СОЦИАЛИСТ ЧИГ
БАРИМЖААТ ОРНУУДЫН
НИЙГЭМ-ЭДИЙН
ЗАСГИЙН ХӨГЖЛИЙГ
ТҮРГЭТГЭХЭД ҮНДЭСНИЙ
БОЛОВСОН ХҮЧНИЙ
ҮҮРЭГ**

3. Эрдэнэчимэг

Нийгмийн нөхөн үйлдвэрлэлийн нэн чухал бүрэлдэхүүн хэсэг нь нийгмийн ажиллах хүчний нөхөн үйлдвэрлэл байдаг бөгөөд тэр нь ажиллах хүчний тоо ба чанарын өөрчлөлтөөр тодорхойлогдоно. Шинжлэх ухаан, техникийн дэвшлийн өнөө үед тусгаар тогтнолоо тунхаглан, улс орноо социалист чиг баримжаагаар хөгжүүлж буй оронд ажиллах хүчний нөхөн үйлдвэрлэлийн чанарын өөрчлөлтийг чухалчилж байна. Социалист чиг баримжаат орнууд үндэсний мэргэжилтэй ажиллах хүчин бэлтгэх асуудлыг хүнд үйлдвэржилт, хөдөө аж ахуйн хоршоолол, улсын сектортой эн зэрэгцүүлэн тавьж байна.

Ер нь мэргэжилтэй ажиллах хүчний өсөлтийг дагаж нийгмийн материаллаг баялаг нэмэгдэхийн хамт хөдөлмөрчдийн оюуны баялаг ч улам бүр өсөн өргөжиж байдаг зүй тогтолтой.

Аливаа нийгмийн үйлдвэрлэлийн өсөлтөд тухайн нийгмийн хөдөлмөрийн нөөц, түүний өсөлт, бүтэц шууд нөлөөтэй байдаг. Ийм учраас мэргэжилтэй ажиллах хүч нь нийгмийн үйлдвэрлэлд тодорхой байр суурь эзлэн, онцгой үүрэг гүйцэтгэгч хүч болдог. Хүн амын тоо, ялангуяа хөдөлмөрийн чадвартай хүмүүс, тэдгээрийн мэргэжил, боловсролын бүтэц, түвшин нь нийгмийн баялагийг бүтээн үйлдвэрлэх,

эдийн засгийг цаашид хөгжүүлэх бололцоог илэрхийлэх шалгуур үзүүлэлтүүдийн бүрэлдэхүүний шийдвэрлэх хэсэг болдог.

Энэхүү үзүүлэлтийг хүн амын ажил эрхлэлтийн түвшингээр хэмждэг. Энэ нь бүх хүний хэдэн хувь нь ажиллаж байгаагаар илэрхийлэгдэнэ.

Хөгжиж буй бүх орнуудын нийт хүн амд ажил хөдөлмөр эрхлэж буй хүн амын эзлэх хувийн жин болон салбаруудад оногдож буй байдлыг доорхи хүснэгтээс харж болно.

Хүснэгт 1

Он	Нийт тоо (мян. хүн)	Нийт хүн амд ажил эрхлэгчдийн эзлэх хувийн жин (хувиар)	Салбаруудад хувиарлагдсан нь					
			Мянган хүн			Хувийн жин (хувиар)		
			Хөдөө аж ахуйд	Аж үйлдвэрт	Үйлчилгээн ий хүрээнд	Хөдөө аж ахуйд	Аж үйлдвэрт	Үйлчилгээн ий хүрээнд
1950	445135	42,0	837559	40789	66787	75,8	9,2	15,0
1970	629023	37,1	410150	86240	132633	65,2	13,7	21,1
1985	885700	-	481821	132855	271024	54,4	15,0	30,6

Ер нь ажиллах хүчний нөөцийг зөв хувиарлаж, ашиглах асуудалд онцгой анхаарах нь чухал бөгөөд хөгжиж байгаа орнуудын өмнө орчин үед ажиллах хүчийг зүй зохистой хувиарлах, тэдгээрийн мэргэжил чадварыг дээшлүүлэн, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх явдал чухал зорилт болж байна.

Хөдөө аж ахуйд ажиллах хүчин илүүдэх явдал хөгжиж буй бараг бүх орны онцлог юм. Африкийн хөдөөгийн ажиллах хүчний 20-50 %, Азийн 20-60 %, Латин Америкийн гуравны нэг хувь нь тус тус илүүдэж байна.

Бие даасан хөгжлийн үед африкийн пролетари нарын дотор гарсан чанарын өөрчлөлт багагүй ач холбогдолтой юм. Тэдний дотор тосгонтой нягт холбоотой хэвээр байгаа хэсүүл тариачдын хувийн жин буурч байна. Тэдний боловсрол, мэргэжлийн түвшин дээшилж, аж үйлдвэрт ажиллагсадын тоо харьцангуй өсөн, төвлөрч байна.

Материаллаг ба материаллаг бус үйлдвэрийн ажилчдын хооронд зохих харьцаа тогтож байдаг зүй тогтолтой билээ. Энэ харьцаа нь орон тус бүрийн үйлдвэрлэх хүчний хөгжил, улс ардын аж ахуйн салбарын бүтцээс шалтгаалж янз бүр байх нь мэдээж юм. Материал баялагийг үйлдвэрлэгч үйлдвэрт ажиллагсадын тооны өсөлт нь үндэсний орлогын өсөлтөд чухал хувь нэмэр оруулдаг боловч шинжлэх ухаан, техникийн эрин үед нийгмийн хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, үндэсний орлогыг арвижуулах гол эх сурвалжийн нэг болгон ажилчдын чанарын өсөлтийг авч үзэх нь бүр ч онцлогтой байна. Иймээс ажиллах хүчний ерөнхий боловсрол, мэргэжлийн түвшинг дээшлүүлэх, түүний эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх нь онцгой чухал зорилт болж байгаа билээ.

Социалист чиг баримжаат орнуудын эдийн засагт энгийн нөхөн үйлдвэрлэлээс өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэлд аажмаар шилжилт явагдаж байна. Түүний хурдац нь орон тус бүрийн үйлдвэрлэх

хүчний хөгжлийн түвшин, эдийн засагт нь гадаадын капитал хэр зэрэг нөлөөлж байгаа болон тэдгээр орны эдийн засгийн суурийн онцлогоос шууд хамаарч байна. Мөн нөгөө талаас нийгмийн давхаргын бүрэлдэн тогтох өвөрмөц замууд нь шинэ суурь бүрэлдэх үйл явцад ч нөлөөлж байна.

Социалист чиг баримжаат орнуудад улсын секторыг бэхжүүлэх, тосгонд хоршоолох хөдөлгөөнийг сайшаан дэмжих, нийгэм-улс төрийн амьдралд хөдөлмөрчид олон түмнийг оролцуулах бодлогыг хэрэгжүүлж байна. Улсын секторт гадаадын мэргэжилтнүүдийн үйл ажиллагааг хязгаарлаж, үндэсний боловсон хүчнийг ажиллуулах нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээ авч байна. Хоцрогдлыг зайлшгүй устгаж, орчин үеийн олон салбартай аж ахуйн систем байгуулах, хөдөлмөрийн зохион байгуулалтын түвшинг дээшлүүлж, орчин үеийн аж ахуйн үр ашиг бүхий арга барилыг нэвтрүүлж эхлээд байна. Өсвөр үеийг хүмүүжүүлэх, хүн амын соёлын түвшинг дээшлүүлэх, уламжлалт соёлоо хөгжүүлэх, боловсролын системийг хөгжүүлж мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх зэрэг нийгэм-эдийн засгийн тулгамдсан зорилтуудыг шийдвэрлэж байна. Материаллаг үйлдвэрлэлийн хүрээнд улсын нэгдлүүдийг байгуулж, удирдах албан тушаалд үндэсний мэргэжилтнүүдийг ажиллуулж эхлэв. Мөн төрийн бүх байгууллагуудыг зохих мэргэжилтэй боловсон хүчнээр хангах чиг шугам баримталж, тодорхой албан тушаалд томилохын тулд тэдний мэргэжлийг дээшлүүлэх бэлтгэл ажил хийж байна. Хөдөлмөрчдийг нийгэм, үйлдвэрлэлийг удирдах хэрэгт татан оролцуулж, удирдлагын ардчиллыг хөгжүүлэх нь тэдний үүргийг дээшлүүлж байгаа нэн чухал хэлбэр юм.

Эдийн засгийн орчин үеийн сектор байгуулж, өндөр мэргэжилтэй боловсон хүчнээр хангах зорилтыг социалист чиг баримжаат орнуудад улс ардын аж ахуйн салбарын бүтэц, түүний хөгжлийн өнөөгийн түвшингээс шалтгаалж янз бүрээр шийдвэрлэж байна.

Хүснэгт 2

Орон	Нэг хүнд ногдох нийт бүтээгдэхүүн	Хөрөнгө оруулалт	Нийт бүтээгдэхүүний хэм хэмжээ		Ажил эрхлэлт		Гадаад худалдааны коэффициент
			Аж үйлдвэрт	Хөдөө аж ахуйд	Аж үйлдвэрт	Хөдөө аж ахуйд	
1. Алжир	2306	40,1	52,2	8,8	25	25	48,6
2. Сейшелийн Арал	1670	32,3	20,8	7,7	-	-	54,5
3. Конго	1293	55,0	44,5	7,4	26	35	97,8
4. Ангол	576	9,3	21,7	19,7	16	59	64,3
5. Мозаибик	407	8,1	14,6	39,3	17	67	22,8
6. Гвиней Бисау	374	22,1	25,3	21,2	-	-	82,7
7. Бенин	278	20,0	14,1	47,3	16	56	60,7
8. Мадагаскар	266	14,6	16,9	44,3	4	87	35,7
9. Танзани	221	19,1	12,7	55,1	6	83	18,0
10. Этиоп	141	15,4	16,5	47,3	7	80	26,4

¹ Азия и Африка сегодня». 1986. 15-22-р тал.

Африкийн социалист чиг баримжаат орнуудын заримд нь аж үйлдвэрийн салбар түлхүү хөгжиж, тэнд ажиллах инженер, ажилчдын тоо өсч, нийгэм-эдийн засгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх үүрэг нь өндөржиж байгаа хэдий боловч ажиллах хүчний ихэнх нь хөдөө аж ахуйд ажиллаж байна. Энэ нь мэргэжилтэй боловсон хүчин дутагдалтай байгааг харуулж байна. Иймд эдгээр оронд ажиллах хүчийг хөдөө аж ахуйгаас аж үйлдвэр, соёлын бусад салбарт шилжүүлэх зорилт тавьж байна. Мөн хөгжиж байгаа орнуудад хөдөө аж ахуйг орчин үеийн түвшинд хүргэх нөөц боломжийг эрэн судалж байна.

Нийгмийн ажиллах хүчний боловсрол, мэргэжлийн түвшин хэдий чинээ өндөр байх тусам түүний хөдөлмөрийн бүтээмж төдий чинээ өндөр байдаг. Гэвч тухайн орны үйлдвэрлэлийн техникжилтын түвшин хичнээн өндөр байх нь хүмүүсийн мэдлэг, боловсрол, оюун санаанд үзүүлэх бодит хүчин зүйл болдог. Мэргэжил нь боловсрол, туршлагжсан дадлага хоёрын нэгдэл бөгөөд түүнээс боловсрол нь суурь болох учир илүү байх ёстой. Иймээс социалист чиг баримжаат орнуудад боловсролын системийг улам боловсронгуй болгон хөгжүүлж нилээд амжилт олж байна. Үндэсний их сургууль нь боловсрол, шинжлэх ухаан, соёлыг хөгжүүлэх эх үндэс болдог. Үндэсний их, дээд сургуулиудад мэргэжилтэн бэлтгэснээр мэргэжилтэй боловсон хүчнээр улс ардын аж ахуйн салбаруудыг хангах, нөгөө талаар шинжлэх ухааны ажилтан, мэргэжилтэн нарыг гадаад орнуудад суурьших явдлаас ангижруулах нэг үндэс болно.

Одоо социалист чиг баримжаат орнуудад сургалтыг үнэ төлбөргүй болгож, бага сургуулиудад хичээлийг төрлөх хэлээр нь заах, сургуулийн тоог олшруулах зэрэг арга хэмжээнүүдийг авч байна. Мөн нийгмийн үйлдвэрлэлийн бүтцийн дэвшилт өөрчлөлт, улс ардын аж ахуйн бүтэц хөгжил нь мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх асуудалтай нягт холбоотой учир дээд сургуулийн сургалтыг улс орныхоо эдийн засагтай уялдуулан чиглүүлж байна. Тухайлбал, Алжирт нефть олборлох, боловсруулахад мэргэжилтэй боловсон хүчин түлхүү бэлтгэх зорилгоор нефтийн мэргэжилтэн бэлтгэх хэд хэдэн сургалтын төвүүдийг байгуулсан байхад Танзани зэрэг эрдэс түүхий эд багатай зарим орнуудад үйлдвэрлэлийн бус хүрээнд ажиллах мэргэжилтэнг түлхүү бэлтгэх жишээтэй байна.

Социалист чиг баримжаат орнуудын их дээд сургуулиуд нь хувьсгалт ардчилсан сэхээтэн бүрэлдэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Социалист чиг баримжаат орнуудад сургалтыг шинэ хэлбэрээр зохион байгуулж, орчин үеийн шинжлэх ухаан-техникийн дэвшлийн түвшинд мэргэжилтэн бэлтгэх зорилт тавьж, хөдөлмөрчдийн шинжлэх ухаан, техникийн мэдлэг, бүтээлч үйл ажиллагааг дээшлүүлэх ажлуудыг зохиож байна.

Социалист чиг баримжаат зарим оронд их дээд сургуулиуд, Яамдын харьяа судалгаа, сургалтын болон сорилтын төвүүд, эрдэм шинжилгээний нийгэмлэгүүд чухал үүрэг гүйцэтгэж байна. Сүүлийн жилүүдэд эдгээр орнуудад шинжлэх ухааныг хөгжүүлэхэд хэд хэдэн орон буюу бүсийн судалгаа сургалтын нэгдсэн төв байгуулах явдал дэлгэрч байна. Дорнод Африкийн шинжлэх ухааны академи, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд үүний нэг тод жишээ юм. Уганда, Танзани, Кени зэрэг орныг үйлчлэх дээрхи судалгааны төвийн дотроос Дорнод Африкийн аж үйлдвэрийн судалгааны хүрээлэн, хөдөө аж ахуй, ойн судлалын хүрээлэн зэрэг нь бүс нутгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж байна. Дээрхи хүрээлэнгийн ажилтнууд физик, хими, хөдөө аж ахуйн механикжилт, ургамал судлал, ургамлын эмгэг судлал, халдвар судлал, байгаль орчныг хамгаалах асуудал зэрэг өргөн хүрээтэй судал-

гаг явуулж байгаа нь улс орны эдийн засгийг төлөвлөгөөтэй, шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байна.

Ийнхүү шинжлэх ухааныг улс орны нийгэм-эдийн засгийн зангилаа асуудлуудыг шийдвэрлэхэд чиглүүлж, эрдэм шинжилгээний ажилтан бэлтгэх, эрдэм шинжилгээний ажлын материаллаг баазыг бэхжүүлэх талаар нилээд амжилт олж байна.

Бүх хүн амын аж амьдрал, соёлын түвшинг байнга дээшлүүлэх, ажиллах хүчинд зохих мэргэжил, боловсрол эзэмшүүлэх арга хэмжээ нь үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын идэвхтэй хэлбэр төдийгүй үр ашгаа хурдан өгөх боломжтой юм.

Хөгжиж байгаа орнуудын «оюуны нөөцийг» элдэв аргаар татан авч өөртөө үйлчлүүлэхийг оролдож байгаа хөрөнгөтөн орнуудын бодлогыг зогсоож, үндэсний их, дээд сургуулиудад боловсон хүчинг бэлтгэн гаргаж, үндэсний эрдэмтэн мэргэжилтнүүдийг эх орныхоо үйлст ажиллуулах асуудал социалист чиг баримжаат орнуудын өмнө тулгарч буй чухал зорилтын нэг болж байна.